



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Энхт ӨЭМТ-ийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/171/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал
Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Санхүүгийн аудитын албаны аудитын менежер: Да.Отгонбаяр
Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:
Бэст фортуна аудит ХХК-ийн захирал: Ж.Оюунцэцэг
Утас: 324338, 89116465, 98056465
Цахим хаяг: fortune2009audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Үндэсний аудитын газар
**НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13 № 896

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЭНХТ ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА С.АЛТАНЦЭЦЭГ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Энхт ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг бүхий л материаллаг байдлын үүднээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй, аудит хийх цаг хугацааны хязгаарлагдмал байдал үүсгэсэн мөн нийт 24.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Баянгол дүүргийн Энхт ӨЭМТ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнээр тооцсон зардлын санхүүжилтээр 486.2 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээний санхүүжилтээр 84.4 сая төгрөгийн, Баянгол

1426050967

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэргийн 2026\2026\word\yusan bichig Dugnel 2026.docx

дүүргийн Эрүүл мэндийн төвөөс 0.8 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тус төв нь эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношлонгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Баянгол дүүргийн Энхт ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 87.6 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 88 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
	2024-12-31	2025-12-31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	159,736.92	862,740.23
Бусад авлага	6,719,016.60	5,417,656.48
Бусад санхүүгийн хөрөнгө	-	
Бараа материал	20,880,373.62	9,890,530.01
Эргэлтийн хөрөнгийн дүн	27,759,127.14	16,170,926.72
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	115,497,560.57	86,376,495.14
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	115,497,560.57	86,376,495.14
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	143,256,687.71	102,547,421.86
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	-	-
Цалингийн өглөг	3,107,093.00	-
Татварын өр	14,918,210.55	3,784,982.94
НДШ-ийн өглөг	10,792,464.14	621,956.64
Бусад богино хугацаат өр төлбөр	-	12,800,000.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	28,817,767.69	17,206,939.58
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	
Өр төлбөрийн нийт дүн	28,817,767.69	17,206,939.58
Эздийн өмч	40,512,292.00	40,512,292.00
Өмч: - төрийн	39,512,292.00	39,162,292.00
- хувийн	1,000,000.00	1,350,000.00
- хувьцаат	-	
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,545,613.50	1,545,613.50
Эздийн өмчийн бусад хэсэг	1,220,100.00	1,220,100.00
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	71,160,914.52	42,062,476.78
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-
Эздийн өмчийн дүн	114,438,920.02	85,340,482.28
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	143,256,687.71	102,547,421.86

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2024-12-31	2025-12-31
Борлуулалтын орлого (цэвэр)	543,918,642.73	572,707,981.60
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)	543,918,642.73	572,707,981.60
Ерөнхий ба удирдлагын зардал	597,885,045.85	601,806,419.34
Санхүүгийн зардал	-	-
Бусад зардал	-	-
Бусад ашиг алдагдал	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(53,966,403.12)	(29,098,437.74)
Орлогын татварын зардал	-	-
Татварын дараах ашиг (алдагдал)	(53,966,403.12)	(29,098,437.74)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(53,966,403.12)	(29,098,437.74)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	(53,966,403.12)	(29,098,437.74)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023-12-31-ний үлдэгдэл	0.00	0.00	-	0.00	0.00
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-		-	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	40,512,292.00	1,545,613.50	1220100	125,127,317.64	168,405,323.14
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-		-53,966,403.12	-53,966,403.12
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	0.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	0.00
2024-12-31-ний үлдэгдэл	40,512,292.00	1,545,613.50	1,220,100.00	71,160,914.52	114,438,920.02
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-		-	-	0.00
Залруулсан үлдэгдэл	40,512,292.00	1,545,613.50	1,220,100.00	71,160,914.52	114,438,920.02
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	-29,098,437.74	-29,098,437.74
Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0	0	0	0.00
Зарласан ногдол ашиг	0	0	0	0	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0	0.00
2025-12-31-ний үлдэгдэл	40,512,292.00	1,545,613.50	1,220,100.00	42,062,476.78	85,340,482.28

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2024-12-31	2025-12-31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	537,981,446.11	571,509,341.72
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	537,981,446.11	571,509,341.72
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	524,096,212.80	566,878,433.41
Ажиллагчдад төлсөн	324,700,688.00	402,323,354.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	46,980,658.78	36,030,998.41
Бараа материал худалдан авахад төлсөн	50,987,995.00	-
Ашиглалтын зардалд төлсөн	-	-
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	369,000.00	279,331.00
Татварын байгууллагад төлсөн	28,690,965.80	57,699,665.62
Бусад мөнгөн зарлага	72,366,905.22	70,545,084.38
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,885,233.31	4,630,908.31
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	14,544,000.00	3,927,905.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,544,000.00	3,927,905.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(14,544,000.00)	(3,927,905.00)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(658,766.69)	703,003.31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	818,503.61	159,736.92
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	159,736.92	862,740.23

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Энхт ӨЭМТ нь завсрын аудитад хамрагдаагүй, санхүүгийн тайланг хуулийн хугацаа хоцроож ирүүлсэн тул зөвхөн ирсэн журнал, баримтуудын хүрээнд үзэж аудитаар нийт 24,700.0 мянган төгрөгийн зөрчил² илрүүлж 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 24,700.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, санхүүгийн тайланг аудитын байгуулагад хуулийн хугацаанд ирүүлээгүй тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажилтнуудад хавсран ажилласны нэмэгдэл цалинг олгохдоо тухайн эзгүй албан тушаалын цалингаас тогтоосон хувиар тооцож олгох ёстой байтал нэмэгдэл цалин авч байгаа ажилтны өөрийнх нь албан тушаалын үндсэн цалингаас тооцож олгосон ба бүтэц орон тоо баталсан тушаал, хавсран ажиллах орон тооны тушаалд үндсэн цалинг тодорхой заагаагүй.	1				1	
НЭМГ-н даргын 2025 оны 2 дугаар сарын 4 ны А/22 тоот тушаалаар өгсөн машиныг нягтлан бодох бүртгэлд орлого аваагүй	1	24,700.0	1	24,700.0		
Дүн	2	24,700.00	1	24,700.00	1	-